MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 10 сарын 07 өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг ажлаас чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Дүрэм"-ийн 5.7.8, "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.5.4, Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч нарын хооронд 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-ний 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.2 дахь заалтууд, Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбатын 2026 оны 10 дугаар сарын 07-ны өдөр гаргасан "Үүрэгт ажлаас чөлөөлөгдөх хүсэлт", Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбатын өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн 2026 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөр тасалбар болгон Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн албан тушаалаас чөлөөлж, түүнтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г дуусгавар болгосугай.

2.Д.Мөнхбатыг чөлөөлсөнтэй холбогдуулан 2026 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн дотор ажил хүлээлцэх акт үйлдэн, ажил хүлээлцэхэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитор Г.Байгалд үүрэг болгосугай.

3.Д.Мөнхбатыг чөлөөлсөнтэй холбогдуулан цалин хөлс, ээлжийн амралт, эд хөрөнгийн тооцоог дуусгавар болгохыг Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэлд даалгасугай.

4.Гүйцэтгэх захирлын үүргийг Захиргаа, санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэнгээр хавсран гүйцэтгүүлэхтэй холбогдуулан эрх бүхий байгууллагаар хянуулах болон бусад шаардлагатай үйл ажиллагааг холбогдох журамд нийцүүлэн шуурхай зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн газарт үүрэг болгосугай.

5.Энэ тогтоолын 4-т заасны дагуу эрх бүхий байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн хавсран гүйцэтгэх асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт даалгасугай.

1526010130

6.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (П.Баяр)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ